Тайлант хугацаанд шимтгэл төлөгч 897 аж ахуй нэгжийн 16727, сайн дурын 5150, эрүүл мэндийн даатгалаа өөрөө хариуцсан төлсөн 12361 даатгуулагчаас нийгмийн даатгалын санд 59,572,623,8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулбал орлого 12,541,194.9 мянган төгрөгөөр өссөн бөгөөд орлогын төлөвлөгөөг 59,572,623.8 мянган төгрөг буюу 96,0 хувиар биелүүлсэн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлогод 54,708,716.3 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 52,458,178.6 мянган төгрөг бүрдүүлж орлогын төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай, тэтгэврийн даатгалын сангаас 16956 тэтгэвэр авагчдад 115,513,284.8 мянган төгрөгийн тэтгэвэр олгож,

тэтгэвэр олгосон зардалд 9,325.7 мянган төгрөг зарцуулан, НДЕГ-т 3,600,175.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн орлогод 3,898,006.6 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 3,673,503.2 мянган төгрөг бүрдүүлж төлөвлөгөөний биелэлт 94,0 хувьтай биелүүлснээс 1342 даатгуулагчид 278,295.1 мянган төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалтын, 1181 даатгуулагчид 2,539,616.5 мянган төгрөгийн жирэмсэн болон амаржсаны, 493 даатгуулагчид 996,000.0 мянган төгрөгийн оршуулгын, нийт 3,813,911.6 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 2,636,031.9 мянган төгрөг төлөвлөснөөс 2,749,204.2 мянган төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 104,0 хувьтай хэрэгжсэн байна.

Тайлант хугацаанд 42 тэтгэвэр авагчдад 306,562.9 мянган төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, рашаан сувиллын зардалд 5 даатгуулагчид 1,033.2 мянган төгрөг тус тус олгож НДЕГ-т 2,290,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Ажилгүйдлийн даатгалын санд 769,239.6 мянган төгрөг төлөвлөснөөс 691,737.6 мянган төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 90,0 хувьтай биелэсэн бөгөөд тус сангаас тайлант хугацаанд 485 даатгуулагчид 1,306,136.0 төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 8,315,314.6 мянган төгрөг оруулж, ЭМДЕГ-т 8,986,674.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь НДЕГ-ын даргатай 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 50 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 91,0%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нэгдмэл төвлөрсөн удирдлагатай ба Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 онд баталсан удирдах 1, гүйцэтгэх 48, үйлчилгээний 5, бүгд 54 орон тооноос тайлант онд гүйцэтгэх 3, үйлчилгээний 1 орон тоо дутуу буюу 50 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газраас өгсөн чиглэл, хэлтсийн даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлага дансны 2022 оны жилийн эцсийн байдлаарх дэлгэрэнгүй судалгааг гаргаж сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт хүргүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна. Цаашид өр, авлага үүсгэхгүй ажиллах, үүссэн өр авлагыг барагдуулах ажлын төлөвлөгөөг 2023 оны 4 дүгээр сарын 13-нд хэлтсийн даргаар батлуулан зохион байгуулж ажилласан болович үр дүн нь хангалтгүй ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагагүй гэж үзсэн.

Тайлант 2023 оны хувьд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод аудитын тасагтай бөгөөд хэлтсийн даргын баталсан "Дотоод аудитын төлөвлөгөө"-ний дагуу 2022 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцооны үндэслэл, мэдээллийн баазад оруулсан байдал, 2022 онд шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэрэг, тэтгэвэр тогтоолт, олголт, баримтын бүрдүүлэлт, эрх зүйн үндэслэл, Нийгмийн даатгалын сайн дурын даатгалын гэрээний хэрэгжилт, шимтгэл төлөлтийн тооцооны үндэслэл, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын ажилд хяналт тавьж, шалган зааварчилж, шалгалтын дүнг хэлтсийн даргад танилцуулж ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2018 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,622,785.62 мянган төгрөгөөр буюу 20,9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10,758,338.2 | 15,337,928.1 | 4,579,589.9 |
| Урьдчилгаа | 0 | 0 | |

| | | | |
|---|---|---|---|
| Авлага | 5,973,189.9 | 5,022,589.7 | -950,600.2 |
| Бараа материал | 15,440.3 | 22,217.9 | 6,777.6 |
| Үндсэн хөрөнгө | 628,177.3 | 615,195.6 | -12,981.7 |
| **Нийт хөрөнгө** | **17,375,145.7** | **20,997,931.3** | **3,622,785.6** |
| Өр төлбөр | 738,552.7 | 1,229,277.8 | 490,725.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 16,636,593.0 | 19,768,653.5 | 3,132,060.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **17,375,145.7** | **20,997,931.3** | **3,622,785.6** |

*Эх сурвалж: Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс 4,579,589.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ үзүүлэлт нь тэтгэврийн даатгалын сангаас олгох 2024 оны 1 дүгээр сарын тэтгэврийн санхүүжилтийг тэтгэвэр олголтын өмнөх сард байршуулдагтай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 5,022,589.7 мянган төгрөг болж, 950,600.2 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвөөс авах авлагын бууралттай холбоотой байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 47,417.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 3,379.0 мянган төгрөгийн үнэт цаас маягтуудыг үнэ төлбөргүй хүлээж авсан бөгөөд 43,940.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/169 тоот тушаалаар Нийгмийн даатгалын газар болон бүтцийн өөрчлөлт хийгдсэн өөрчлөлтийн хүрээнд албан тоотын хэвлэмэл хуудас, тэтгэврийн хувийн хэрэг шинэчлэх зэрэг ажлуудыг хийлгэхээр авсан бичгийн цаас, принтерийн хор зэргээр бараа материалын нөөц үүсгэснээс 6,777.6 мянган төгрөгөөр үлдэгдэл өссөн байна.

НДЕГ-ын 2023 оны А/89 тоот "Хангамжийн материал данснаас хасах" тухай тушаалын дагуу нийгмийн даатгалын дэвтэр 181 ширхэг 111.8 мянган төгрөгийн, тэтгэврийн дэвтэр 197 ширхэг 98.5 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын дэвтэр 92 ширхэг 36.8 мянган төгрөгийн, үндсэн ажлаас гадуурх дэвтэр 24 ширхэг 11.4 мянган төгрөгийн, нийт 258.4 мянган төгрөгийн анхан шатны маягтыг данс бүртгэлээс хасаж, устгах ажлыг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн хяналтын дор холбогдох журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/200 тушаалаар хуваарилсан 4,980,910 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, Мэдээлэл тооцооллын төвөөс 1,890.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн хүлээн авч бүртгэж, цаашид ашиглах боломжгүй 20,804.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж хассан байна. Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 41,818.1 мянган төгрөг байна. Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 615,195.6 мянган төгрөг болж, 12,981.7 мянган төгрөгөөр буурсан байна.

НДЕГ-ын 2023 оны А/92 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах журмын дагуу "Хөрөнгийн тооллого хийх, тооллогын ажлын хэсэг байгуулах тухай" хэлтсийн даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар жилийн эцсийн бараа материал болон үндсэн хөрөнгийн тооллого хийж гүйцэтгэн архивын нэгж үүсгэсэн байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 1,229,277.8 мянган төгрөг болж 490,725.11 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс олгосон тэтгэврийн даатгалын санхүүжилттэй холбоотой өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 19,768,653.5 мянган төгрөг болж 3,132,060.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны зардалд 1,126,689.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр тэтгэмжийн зардалд 103,535,970.8 мянган төгрөг, нийт 104,662,660.0 мянган төгрөгийн зардлыг төлөвлөж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 31,519,057.2 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тус хэлтсийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2023 оны үйл ажиллагааны зардлыг 89,530.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,216,219.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 10,386,544.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 113,922,514.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын орлогыг 7,125,747.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 38,644,804.4 мянган төгрөгөөр, улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 14,233,415.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолоор, 2023 оны 12 дугаар сарын 21- ний өдрийн 14 дүгээр тогтоолоор 2 удаа төсвийн тодотгол хийж, тус хэлтсийн 2023 оны үйл ажиллагааны зардлыг 1,595,036.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 124,326,590.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлогыг 62,011,994.4 мянган төгрөгөөр, улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 17,362,862.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 9 арга хэмжээний зардалд НДЕГ-ын даргын 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” А/105 дугаар тушаалаар 125,921,627.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны зардалд 1,595,036.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн зардалд 124,326,590.4 мянган төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Тайлант онд НДЕГ-аас тэтгэврийн даатгалын санд 71,583,570.7 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 373,109.9 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 346,269.1 мянган төгрөг, нийт 72,302,949.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, улсын төсвөөс 17,362,862.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлогоор 50,884,927.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 189,794.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас санхүүжих үйл ажиллагааны санхүүжилтэд 1,595,036.8 мянган төгрөг, нийт 142,335,570.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, тэтгэвэр тэтгэмжийн зардалд 112,110,212.4 мянган төгрөг, үйл ажиллагааны урсгал зардалд 1,395,603.6 мянган төгрөг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдлээс 199,433.2 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71901 –Нийгмийн даатгал<br>80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,495,095.8 | 1,302,620.4 | 192,475.4 | 100% |
| 2 | 71901 –Нийгмийн даатгал<br>80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 7,425.0 | 2,426.6 | 4,998.4 | 32.7% |
| 3 | 71901 –Нийгмийн даатгал<br>80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал | 3,000.0 | 2,914.0 | 86.0 | 97.1% |
| 4 | 71901 –Нийгмийн даатгал | 400.0 | 0 | 400.0 | 0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 80213-Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс | | | | |
| 5 | 71901 –Нийгмийн даатгал<br>80224-Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 41,229.6 | 39,927.2 | 1,302.4 | 96.8% |
| 6 | 71901 –Нийгмийн даатгал<br>80802 -Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 39,619.4 | 39,619.4 | 0.0 | 100% |
| 7 | 71901 –Нийгмийн даатгал<br>80813-Хуульд заасан үндэслэлээр алба | 2,300.0 | 2,244.0 | 56.0 | 97.6% |
| 8 | 71901 –Нийгмийн даатгал<br>80820-Бусад тусламж, дэмжлэг зардал | 5,967.0 | 5,852.0 | 115.0 | 98.1% |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 1,595,036.8 | 1,395,603.6 | 199,433.2 | 87.5% |
| 9 | Нийгмийн даатгалын сан<br>Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 124,326,590.4 | 112,110,212.4 | 12,216,378.0 | 90.2% |
| | Нийт дүн | 125,921,627.2 | 113,505,816.0 | 12,415,811.2 | 90.1% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансанд Төв аймгийн Засаг даргын А/826 тоот захирамжаар 16,000.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн авч 9 сумыг олон үйлдэлт хэвлэгчээр хангаж, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд авч, тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус байгууллага тайлангийн хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71901- Нийгмийн даатгалын үйл ажиллагаа | 2022.01.01-2022.12.31 | Үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах 8 арга хэмжээ | Бүрэн хэрэгжсэн, биелэлт 87.5% | 1,595,036.8 | 1,395,603,6 |
| 2 | Нийгмийн даатгалын сан Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 2022.01.01-2022.12.31 | Нийгмийн даатгалын 4 сангийн үйлчилгээг хүргэх | Бүрэн хэрэгжсэн, биелэлт 90.2% | 124,326,590.4 | 112,110,212.4 |
| | | | Нийт дүн | 90,1% | 125,921,627.2 | 113,505,816.0 |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 21 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн тайланг, нэгтгэсэн тайлантай хамт 2024 оны 3 дугаар сарын 05-ны 64 тоот албан бичигт хавсарган ирүүлсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга болон цаасаар цахимаар ирүүлэх бусад материалуудын иж бүрдлийг хангаж ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтээр Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын 81,587,053.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 1,223,805.8 мянган төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0% буюу 917,854.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хавсаргаж ирүүлсэн байна.

Тус байгууллага нь үйл ажиллагааны зардлаасаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлснээр Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу тус хэлтсийн аймгийн төвийн албан хаагчид, ойролцоо сумдын байцаагч нараар ажил давхар хавсруулах байдлаар хариуцуулан хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж 4-9 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 176,551.8 мянган төгрөгийг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,477.3 мянган төгрөгийг, сүүлийн хагас жилд жолоочийн орон тоог хэмнэж автомашины хэрэглээг хязгаарласнаас тээвэр шатахууны зардлын 14,130.0 мянган төгрөгийг, бичиг хэргийн зардлаас 6.3 мянган төгрөгийг, 8 удаагийн сургалтыг цахимаар зохион байгуулж албан томилолтын зардлаас 3,960.7 мянган төгрөгийг, бусад урсгал зардлуудаас 3,307.1 мянган төгрөгийг, нийт 199,433.2 мянган төгрөгийн төсвийн бодит хэмнэлтийг төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төлөвлөсөн зарим арга хэмжээг нэгтгэн зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хэлтсийн болон сумдын байцаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны чиглэл зөвлөмж өгөх сургалтыг 8 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангахаар Нийгмийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын сан гэсэн 2 цахим цэс үүсгэсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дээрх 5 мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудаст байршуулсан мэдээ тайлантай тулган нийцлийн аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн 1,2,3 дугаар улирлын байршуулах бүх мэдээллүүдийг байршуулаагүй, мэдээлэл байхгүй байдалтай илгээсэн зөрчил байна.
2. Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар шивж оруулаагүй, PDF форматаар байршуулаагүй, орон тооны мэдээллийг 11 удаа мэдээлээгүй, худалдан авах ажиллагааны тайланг байршуулаагүй зөрчил байна. Аудитын явцад тендер шалгаруулсан худалдан авах ажиллагаатай холбоотой 42,884.0 мянган төгрөгийн 3 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 48,687.0 мянган төгрөгийн 6 мэдээлэл, төсөв өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 36,364.0 мянган төгрөгийн 11 шийдвэр, нийт 3 төрлийн 127,935.0 мянган төгрөгийн 20 мэдээллийг нөхөн байршуулснаар хуулийн хэрэгжилтийг 47 хувьтай хангууллаа.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Нийгмийн даатгалын сангийн шилэн дансанд байршуулах мэдээллүүдийг тайлант оны 1, 2, 3 дугаар улиралд байршуулаагүй, Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар шивж оруулаагүй, PDF форматаар байршуулаагүй, орон тооны мэдээллийг 11 удаа байршуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг

байршуулаагүй, шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” 5 дугаар зүйлийн 5.1.3-д “тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх”, 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэж заасантай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "оршин байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-д " аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа, нийгмийн даатгалын сангийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн 1 төлбөрийн акт, 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 196 тоотоор ирүүлж, fas.audit.mn системд бүртгэсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 392.7 | 1 | 392.7 | 100% |
| Албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | 100% |
| Зөвлөмж | 3 | 10,911.6 | 3 | 10,911.6 | 100% |
| Нийт дүн | 5 | 11,304.3 | 5 | 11,304.3 | 100% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулах замаар орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгааг анхаарал татахуйц асуудлаар тодорхойлж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нэмэлт санхүүжилтийн тайланг өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй 1,000.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 54 дүгээр зүйлийн 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" журмын 2.1.8-д "Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад төсвийн байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэхүйц" байх зарчим болон санхүүгийн тайлангийн "толилуулга", "иж бүрэн байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

Аудитаар нийт 1,121,665.6 мянган төгрөгийн 5 зөрчил[2] илэрсэнд, 502.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,120,751.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж ( нэг зөрчил нь нийцлийн аудитын асуудал тул энэ тайлангийн 4.4.2-д шийдвэрлэлтийг тайлагналаа), зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 412.4 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө. Үүнд:

### 5.1 Төлбөрийн акт

НДЕГ, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс сумдад томилолтоор ажилласан 12 албан хаагчид албан томилолтоор ажиллах үеийн хоолны нөхөх төлбөр, албан хаагчийн хоолны зардлын нөхөх төлбөрийг давхардуулан тооцож 122.0 мянган төгрөг илүү олгосон, унааны зардалд анхан шатны баримтгүй 380.0 мянган төгрөгийг олгож нийт 502.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

1. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх тайлант оноос 1,120,751.2 мянган төгрөгөөр буюу 57,4 хувиар өссөн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ", НДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны 06 дугаар тогтоолын 4-д "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, шимтгэлийн авлагыг барагдуулах замаар орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх..." заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "тасалбар болголт", "толилуулга", "ангилал", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" үүссэн бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***1.1.Илрүүлэлт:***

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд "...нийгмийн даатгалын санд 44,649,132.3 мянган төгрөгийн шимтгэлийн орлогоос 45,497,465.8 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 101,9 хувьтай гэх боловч санхүүгийн тайлангийн гүйцэтгэлээр Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөний биелэлт 96,1 хувьтай, төлөвлөгөөг биелүүлээгүй зөрүүтэй тайлагнасан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д "нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах", НДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны 06 дугаар тогтоолын 4-д "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, шимтгэлийн авлагыг барагдуулах замаар орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх..." заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

***1.2. Өгсөн зөвлөмж:*** Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг төрөл тус бүрээр жигд хангаж биелүүлэх, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргаж тайлагнах

## *2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал*

***2.1.*** ***<u>Илрүүлэлт:</u>***

Албан томилолтын зардлаас тээвэр шатахууны зардалд 412.4 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, шууд зардалд бичсэн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***2.2.*** ***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүжүүлэх зардлын зүйл ангийг зөв тодорхойлох

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д " Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" заалтын дагуу ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх оны үзүүлэлттэй зэрэгцүүлсэн хэлбэрээр тайлагнах | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | | | |
| Дүн | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | 0 | 0 | 0 | 0 |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан томилолтоор ажиллах үеийн хоолны нөхөх төлбөрт нийт 502.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил байна. | 1 | 502.0 | 1 | 502.0 | | | | | | | | |
| Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх оноос 1,120,751.2 мянган төгрөгөөр буюу 57,4 хувиар өссөн зөрчил байна. | 1 | 1,120,751.2 | | | 1 | 1,120,751.2 | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөний биелэлт 96,1 хувьтай, төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчил байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Албан томилолтын зардлаас тээвэр шатахууны зардалд гүйлгэн зарцуулж, шууд зардалд бичсэн зөрчил байна. | 1 | 412.4 | | | | | 1 | 412.4 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | 4 | 1,121,665.6 | 1 | 502.0 | 1 | 1,120,751.2 | 2 | 412.4 | | | | |

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны байршуулах мэдээллүүдийг 1, 2, 3 дугаар улиралд байршуулаагүй, Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг оруулаагүй, орон тооны мэдээллийг 11 удаа байршуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй, шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |